

ХҮННҮГИЙН ХИЛ ХЯЗГААР, НУТАГ ДЭВСГЭР (МЭӨ 176-128 ОНЫ ҮЕЭР)

П.ДЭЛГЭРЖАРГАЛ¹, З.БАТСАЙХАН²

¹МУИС, ШУС, Түүхийн тэнхим, e-mail: deegii@num.edu.mn

²МУИС, ШУС, Антропологи-Археологийн тэнхим, e-mail: batsaihan@num.edu.mn

ТҮЛХҮҮР ҮГ: Хүннү, нутаг дэвсгэр, хил хязгаар, газрын зураг

ТОВЧ АГУУЛГА: Хүннү гүрэн нутаг дэвсгэрээ хамгийн их тэлсэн үе буюу хамгийн хүчирхэг байсан МЭӨ 176-128 үеийн нутаг дэвсгэр, хил хязгаарыг газрын зурагт буулган зурсан маань хэд хэдэн номонд хэвлэгдсэн билээ. Энэхүү зургийг зурахын тулд хийсэн судалгаа, газрын зургийн үндэслэлийг өгүүлэл болгон, газрын зургийн хамт хэвлүүлж байна.

Байлдаант улсын үе (МЭӨ Ү-III зуун) гэхэд хятадад төмрийн үйлдвэрлэл эрчимтэй хөгжиж эхэлсэн бөгөөд ялангуяа, хөдөө аж ахуй, газар тариалангийн багаж зэвсэг хүнд төмөр анжис хийх болсноор атар газрыг эзэмшин хагалбарлах нь үлэмж нэмэгдэж эхэлснээр урьд өмнө нь хүннү нарын малын билчээр байсан нутгийг эзлэн түрэмгийлэх замд хятадын төр улсууд шилжин орсон. Энэ нь нүүдэлчдийн эсэргүүцэл тэмцлийг улам өдөөж түүнээс улбаалан Хан улсын хил хязгаарыг уулгалан довтлох нь ихэссэн байна. Хүннүгийн шаньюй нар газар нутгийн бүрэн бүтэн байдлыг ихээхэн чухалчлан үздэг байсан тухай сурвалжид цөөн боловч мэдээ бий. Тухайлбал, Чюнье дүүргийн эсрэг этгээдэд Хангийн нутаг руу түрэн орсон баялаг зурвас газрыг тэгш шугамаар таслан өгөхийг бие хамгаалах харуулын албаны дарга Сяхоу фань шаньюйгаас шаардахад”..... баруун этгээдийн хүннү нар энэ газрын модоор тэрэг, гэр хийх бөгөөд манай өөд болсон эцгийн газар тул би хэрхэн салж зүрхлэх билээ” гэж хариулсан байдаг (Таскин 1973:46,47).

XVIII зууны дунд үеэс Хүннү судлал хөгжиж эхэлснээс хойш Хүннүгийн нутаг

дэвсгэр, хил хязгаарын асуудлыг судлаачид хөндөн авч үзэж, янз бүрээр бичиж дүрсэлсээр иржээ.

Хүннүгийн нутаг дэвсгэрийг “Модун шаньюйн үед, түүний улсын нутаг дэвсгэр нь өмнө зүг цагаан хэрэм, Ордос нутаг, умар зүгт Байгал нуур, баруун зүгт Ил, Тарвагатай, Синьзян, дорно зүгт хойд Солонгос хүртэл” гэх буюу, эсвэл “баруунаас Дорнод Туркестаны хот улсууд, зүүн зүгт дорнод ху аймгийн нутаглаж байсан Ляо голын эх, өмнө зүгт хятадын цагаан хэрэм, хойд зүгт Байгал нуур” хүртэл байснаар ерөнхий тойм байдлаар авч үздэг.

А.Херманы Хятадын болон Төв Азийн эртний улсуудын нутаг дэвсгэрийн талаарх олон жилийн судалгаандаа тулгуурлан туурвисан “Хятадын түүхийн атлас” хэмээх бүтээл нь Монголын эртний улсуудын нутаг дэвсгэрийн судалгааны суурь бүтээл болдог боловч түүний саналд онцлог зүйлс бий. Тухайлбал, Хүннүгийн зүүн хил Маодуний үед, Их Хянганы нуруугаар байх боловч, Ляохэ голын тохойг багтааж байснаар, баруун хилийг бүр Арал тэнгис, Уралын нуруу хүрч байснаар, баруун өмнөд хилийг Памирын

нуруунд тулгаж улмаар Такла-Маканы хотгор бүхэлдээ Хүннүгийн мэдэлд багтаж байснаар дүрсэлжээ. Өмнөд хилийн хувьд Наньшаний нуруу болон Цагаан хэрмээр, харин умард хил нь Тоболь, Ишим, Эрчис мөрний дунд бие хийгээд Сийлхэм, Тагны уулсаар Орхон Сэлэнгийн бэлчир хүрээд Онон мөрний эхээр дамжин Шилка голын доод урсгалд хүрч байсан гэж үзжээ. Мөн МЭӨ 128-36 оны үеийн Хүннүгийн хилийг дүрсэлсэн байх бөгөөд энэ үед хүннүчүүд Ордос, Эзэн голын сав нутгийг Хань улсад алдсанаар зурагдсан төдийгүй Хүннүгийн баруун хил Тэнгэр уулын араар, Илийн савд хүрээд Тарвагатайгаар Эрчис мөрний эх хүрч байснаар зурагдсан байна (Негтманн 1966).

Доктор Ж. Гэрэлбадрах “Хүннү улсын өмнөд хил нь МЭӨ 198 онд Хан улстай байгуулсан гэрээ ёсоор Цагаан хэрмийн дагуу Ляодун мужаас эхлэн зүүн тийш одоогийн Ганьсу мужийн Ланьжоу хот хүртэл үргэлжлээд улмаар Нань шань уулыг дамнан Тэнгэр уул хүртэл байжээ. Хүннүгийн умард хил хязгаарын тухайд гэвэл Эрчис мөрнөөс эхлэн Оросын Алтайн умард бэл, зүүн баруун Саяны нурууны ар бэлээр дамнан улмаар Ангар, Ока голын бэлчир хүрч зүүн тийш Лена, Витим голуудын эхийг хамран Шилка, Хар мөрөний бэлчир хүрч байна. Хүннүгийн дорнод хил нь Хар мөрөн, Шилка голуудын бэлчирээс урагшлан Их Хянганы нурууны зүүн биеэр Нон, Сунгари мөрний бэлчирт тулан өмнө зүг Хан улсын Ляодун муж хүрч байжээ. Өрнө этгээдэд хүннүгийн хил Тэнгэр уулаас хойшлон Или Тарвагатайн нуруу, Эмээл голын хөндийгөөр Эрчис мөрөнд тулж байсан” (Гэрэлбадрах 2004:24) гэж үзжээ.

Судлаач Б.Батсүрэн аливаа улсын нутаг дэвсгэр, хил хязгаар нь тухайн улсын хөгжлийн мандал, бууралтай шууд холбоотой байсан эртний үед Хүннүгийн нутаг дэвсгэрийг: 1) МЭӨ III зуун- МЭӨ 209 он, 2) МЭӨ 209 – 177 он, 3) МЭӨ 177 -128 он, 4) МЭӨ 127-58 он, 5) МЭӨ 58- МЭ 48 он, 6) МЭ 48 – 93 он гэсэн 6 үед хуваан, үе шат бүрийн хүннүгийн түүхэн нутаг дэвсгэр, хил хязгаарыг зурах санал дэвшүүлэн, газрын

зургийг зурсан (Батсүрэн 2003) нь арга зүйн чухал ач холбогдолтой болсон байна.

Бид Хүннүгийн хамгийн хүчирхэг байсан үе МЭӨ 176-128 он буюу хэт их гүрний хэмжээнд 80-аад жил байсан үеийн Хүннүгийн нутаг дэвсгэр, хил хязгаарыг газрын зурагт дүрслэхийг зорив (Зураг 1-д өгсөн газрын зургийг харна уу).

Хүннүгийн өмнөд хилийн асуудал харьцангуй тодорхой байдаг ба энэ тухай сурвалжид “Байлдаант улсын үед гурван вант улс хүннүтэй хиллэдэг” (史記. 2886) гэжээ. Энэхүү гурван улс нь Янь, Чжао болон Цинь улс бөгөөд МЭӨ 221 онд Цинь Ши хуанди олон ванлигийг нэгтгэн нэг улс байгуулаад нүүдэлчдийг умар зүг шахах бодлого явуулж өөрийн цэргийн жанжин Мэн Тяньд 100 мянган цэрэг захируулан МЭӨ 214 онд умар зүгт илгээжээ. “Циньчүүдийг эс дийлэхээ мэдсэн тэрбээр (Түмэн шаньюй - П.Д.) умардад шилжин суув [мөн “Тоумань Циньг дийлж эс чадсан тул умард руу явжээ” гэсэн орчуулга байдаг]” (史記. 2888). Сурвалжийн энэ мэдээг, Цинь улс “... цэрэг хөдөлгөж Хүннү нарын нутгийн өмнөд хэсгийн Ордос болон одоогийн Өвөр Монголын Хөх хот, Бугат хот орчмын газар нутгийг эзлэн авч урд талаар нь цагаан хэрэм нэмэн босгожээ” гэж судлаачид тайлбардаг. Харин зарим нь хүннүчүүд Ордос нутгийг бус “Синьциньчжун” гэдэг нутгийг орхин Иньшань уулын ард шилжин суусан (Ковалев 2002:160-178) гэж үздэг. Иймд Ордосын Бор тохойг зарим тохиолдолд Хан улсын газар нутагт болон Хүннүгийн газар нутгийн хүрээнд оруулах мэтээр тэмдэглэжээ. Сурвалжийн мэдээг нягтлан үзвэл, Хүннү нар Цинь улсад цохигдон Ордос нутгаа алдсан гэдэг нь түүхэн үнэнд төдийлөн нийцэхгүй байна. Нөгөө талаар хүннүгийн археологийн дурсгалын тархалтаас үзвэл Ордосын Бор тохойд таван газарт тэмдэглэгдсэн зэргээс харахад дурдсан газар нь хүннүгийн уугуул нутаг дэвсгэр гэх үндэстэй.

Нөгөө талаас Бор тохойн доторхи газар нь Хатан голыг гатлахгүйгээр саад бэрхшээлгүй

шууд Хан улсад довтлох стратегийн түшиц газар байсан тул Цинь, Хан улсын үеэс эхлээд үеийн үед Бор тохойг эзлэн авч эрх мэдэлдээ барьж байхыг аль аль нь эрмэлзэж байсан юм. Цинь улсын үед олон вант улсууд тус тусдаа байгуулсан хэрмийг залган барьснаар алдарт цагаан хэрэм байгуулагдсан бөгөөд түүхийн дараа дараагийн үед нүүдэлчид болон хятадын төр улсуудыг зааглаж байсан уламжлалт хилийн дээс ажээ. Гэхдээ хятадын улсууд нүүдэлчдийг умар зүг шахан, булаан авсан нутгаа баталгаажуулах зорилгоор цагаан хэрмийг байнга умар зүг шахан барьж байсныг анхаарах шаардлагатай.

Сурвалжийн мэдээнээс үзвэл, хүннү нар хуньюй, цюйшэ, гэгун болон синьли аймгийг эзлэн авсан тухай дурьдсан байдаг.

Хүннүгийн Баруун хил хязгаарын тухай сурвалжид: “Баруун зүгт Юэчжи, ди болон цян нартай хиллэдэг” (史記. 2891) тухай өгүүлсэн байхаас гадна МЭӨ 176 нд Маодунь шаньюйгаас Хан улсын эзэн хаанд явуулсан захидалд “Баруун сянь ванг шийтгэн баруун зүгийн юэжийн эсрэг илгээв. Тэнгэрийн ивээлээр цэрэг дарга нарын лагшин тунгалаг, агт морь тарган байж, надад юэжи нарыг устган буулгаж авах завшаан тохиов. Би лоулань, усунь, хузе болон тэдэнтэй хөрш хорин зургаан эзэмшлийг номхотгосонд бүгд хүннүд дагаар оров. Ийнхүү нум татагч бүх ард түмэн нэгэн гэр бүлд багтаж, энх амгалан тогтов” (史記. 2896) хэмээснээс үзэхэд баруун зүгт хил хязгаарыг үлэмж өргөтгөн тэлсэн нь тодорхой. Энэ нь археологийн дурсгалын тархалтаар батлагдаж байгаа бөгөөд Зүүн өмнөд Казахстанд хоёр газарт хүннүгийн археологийн дурсгал илэрсэн байна. Модунь шаньюй энэ удаагийн аян дайнаар баруун бүс нутагт ноёрхлоо тогтоосон нь Хүннүгийн хувьд ихээхэн чухал ач холбогдолтой байсан билээ. Сурвалжийн дээрх мэдээг судлаачид хэрхэн тайлбарлан ойлгож байгаагаас шалтгаалан баруун хилийг ялгаатай дүрслэн зурсан нь бий.

Лаошан шаньюйн үед Хүннү нар Юэжийн эсрэг гурав дахь удаагаа томоохон

аян дайн хийсэн бөгөөд энэ талаар “Түүхэн тэмдэглэл”-ийн 123 дугаар бүлэг Даюаний шастирт “Хуучин тэд [Юэжи] ихээхэн хүчирхэг байсан бөгөөд Хүннүг тоодоггүй байв. Модуний үед Хүннү хүчирхэгжин, тэрээр Юэжиг довтлон ялсан. Лаошан Хүннүгийн шаньюй байх үед тэд Юэжийн ванг алж, түүний гавлын ясаар гавал аяга хийжээ. Угаасаа Юэжи нар Цилян, Тэнгэр уул ба Дуньхуаны хооронд сууж байсан. Гэвч Хүннүд ялагдсаны дараа тэд алс хол нүүж, Даюаний өнгөрч, баруун зүгт Дася руу довтлон эзлэв. Дараа нь Гүйшүй (Амударьяа мөрөн) голын умард хөвөөнд нийслэл байгуулж, тэнд ван нь суух болсон” (史記. 3168) гэжээ.

НТӨ 176 онд Модунь шаньюйд цохигдсон Юэжи нар Ганьсугийн коридороос Ил мөрний хөвөө рүү нүүж, тэнд суурьшин байсан Сака аймгуудыг эзлэн авчээ. Юэжи нарыг Ил голын хөвөөгөөр нутаглаж байхад нь Лаошан шаньюй довтолж, ванг нь алсан. НТӨ 166/162 онд болсон Хүннүгийн довтолгооны улмаас Юэжи нар баруун зүг нүүж, Ферганы хөндийг гатлан, Бактри улсыг эзлэн авч, улмаар Амударьяа мөрний нутгаар төвлөн суужээ.

Ийнхүү Хүннү нар баруун тийш хийсэн гурван удаагийн аян дайны үр дүнд Дорнод Туркестан, Дундад Азид ноёрхоо тогтоон, газар нутгаа тэлсэн байна.

“Монгол улсын түүх”-ийн тэргүүн ботид “Үсүн нарын баруун талын Өлсгөлөнгийн хээрт нутаглаж байсан Кангюй нар бас Хүннүгийн захиргааг нэрийн төдий ч гэсэн хүлээж байсан байна. Үсүн, Кангюй нарын урдуур Сыр-Дарья, Аму-Дарья мөрний хооронд одоогийн Самарканд хотын орчин тойронд нутаглаж байсан Иран угсааны суурьшмал Согд нар хүннүгийн захиргаанд ороогүй боловч ... Хүннү нарт ямар нэгэн аюул занал учруулахгүй байжээ. Юэчжи нарын нутгийг эзлэн авснаар Лаошань шаньюй Хүннү гүрний баруун талын хил хязгаарыг бататган тогтоож чадсан” (Монгол

улсын түүх, Тэргүүн боть. 2003) хэмээн үзсэн байдаг.

Хүннү нар баруун ба баруун өмнө талаар Хан улсаас гадна Түвэдийн өвөг дээдэс болон эртний иран болон түрэг ард түмнүүдтэй шууд хил залган оршин сууж өрнө дорныг холбосон гол гол зангилаа зам харгуйг хяналтандаа барьж байсан төдийгүй баруун зүгийн улс орнуудтай соёлын талаар өргөн холбоо харилцаатай байсан нь сүүлийн жилүүдэд явуулж буй археологийн сурвалжаар батлагдаж байна. Хүннү улс баруун зүгийн улс орнуудын талаар аль болох Хан улстай холбоо сүлбээ тогтоолгохгүй байхад чиглэсэн улс төр, дипломат бодлогын чиг шугамыг хатуу баримталж байсан юм. Иймээс Уди хааны үеэс эхлэн баруун зүгт нэвтрэх улмаар хүннүгийн эсрэг холбоо тогтоон, чөлөөтэй нэвтрэн худалдаа арилжаа хийх ялангуяа, домогт тэнгэрийн хүлгийг олж авахыг санаархаж байсан аж. Тийм учраас баруун зүгийн газар нутаг стратегийн хувьд асар их ач холбогдолтой өрнө зүгт нэвтрэх үүд хаалга байсан бөгөөд МЭӨ 110, МЭ 73 онуудад Хан улс түр хугацаагаар торгон замыг хяналтандаа оруулж байжээ. МЭ 106 онд Баруун хязгаарт дахин хятадыг эсэргүүцсэн томоохон бослого дэгдсэнээр тус бүс нутгийг бүрэн эзлэх гэсэн оролдлого бүтэлгүйтжээ (Крюков нар 1983:130). Түүхэн эх сурвалжуудыг нягтлан үзвэл, хүннү нар баруун тийш нутаг дэвсгэрээ өргөтгөн одоогийн Шиньжан болон Казахстан улсын нутаг дэвсгэрт хяналтаа тогтоогоод зогсохгүй алс өрнөд тийш өөрийнхөө нөлөөг тэдэнд тулган хүлээлгэж, магадгүй тэр үеэс дорно - өрнийг холбосон Торгоны гэгддэг худалдааны олон улсын зам харилцааны анхны хувилбар бий болсон гэх таамаглалыг дэвшүүлж болохоор байгаа юм (Yue 1990: 128; Barfield 2001: 21, 22).

Судлаач Б. Батсүрэн “МЭӨ 204 онд Алаша, Ганьсугаас хөөгдсөн юэчжи нарыг баруун зүгт нүүн Долоон голын нутагт суурьшсаныг, хүннү, усуньтай хамсан довтолж цааш нь дундад Ази руу хөөгөөд, улмаар тэр хавийн хуцзе аймаг [Алтайн өмнөд бэлээр нутаглагч] мөн шаньюйн зөвшөөрлөөр

Долоон голд нутаглах болсон усунийг, түүнчлэн Лоб нуур хавийн Лоулань (крорайна) зэрэг баруун газрын иран, түрэг угсаат 36 улсаас ... 26 улс, хот-улсыг (хятад сурвалжийн мэдээгээр) албат түшмэг улс болгосноо Хань улсад албан ёсоор мэдэгдэж байжээ” (Батсүрэн 2003:25) хэмээн тайлбарласан байна. Түрүү Хан улсын үед хятадуудын баруун хязгаар гэх газар зүйн ойлголтын дор зөвхөн Кашгарыг оруулан үздэг байсан ба Памир энэхүү газар нутагт багтдаггүй байжээ. Памир хүрдэг хэмээх сурвалжийн заалт нь бодит баримттай бүхэлдээ зөрчилддөг болохыг судлаачид тэмдэглэжээ (Малявкин 1989:71). Уди хаан МЭӨ 138 оноос эхлээд Жан Цянийг сэм хил давуулан баруун хязгаарыг тандуулахаар явуулсан бөгөөд тэрээр замдаа хүннү нарт баригдан 10 гаруй жил байж сая оргон гарч цааш явж, Согд, Тохараар дамжин Бактри хүрч чадсан ажээ. Тэрээр алс баруун болон баруун өмнө зүгийн Дундад Ази, Ойрхи Дорнод, Иран, Афганистаны нутгийн баян тансаг улсууд, тухайлбал, Балхаш нуурын өмнө талын Кангюй, түүний өмнөх Ферганы хөндий, хожмын Самарканд хавийн Согд, Аму-Дарьяа мөрний эхний урсгалын Тохар, түүний өмнөд дэх Бактрия (Дася), умард Ираны Парфия (Аньси), Тигр Ефрат мөрний хоорон дахь Месопотами (Тяожи), Кипчакуудын талаар тодорхой мэдээ цуглуулж, бусад олон улсын тухай анх удаа сонсон мэдэж аваад нутгийн зүг буцсан бөгөөд Уди хаан Жан Цяниас анх алс баруун нутгийн тухай тодорхой мэдээтэй болж, баруун зүгийн улсуудтай харилцах бодлогоо тодорхойлсон байна. Энэ үеийг хүртэл баруун зүгийн эдгээр улсууд дан ганц хүннүгийн эрхшээл болон нөлөөнд байсан ажээ. Сурвалжид өгүүлснээр баруун хязгаарын ихэнх улс суурьшмал амьдралтай. [Янь] Шигу хэлсэн нь: Суурьшмал гэдэг нь байнгын оршин суух газартай, мал адуулан нүүдэггүй, хот сууринтай, газар хагалан, мал аж ахуй эрхэлнэ. Зан заншил нь хүннү ба усуний зан заншлаас ялгаатай. Юуны өмнө тэд хүннүгээс хараат оршино. Хүннүгийн баруун жижу вангийн томилсон тунпу дувэй баруун

хязгаарыг захирах бөгөөд Яньци (Карашар), Вэйсуй (Корла) болон Юйлигийн (Каракун) хооронд байнга сууж хараат эзэмшлүүдээс татвар хураана (Малявкин 1989:56).

Баруун өмнөд хил хязгаарын тухай сурвалжид, МЭӨ 88 онд хүннү нар элчээр дамжуулан бага юэчжи, болон олон цян аймагт “Хангийн 100 мянган цэрэг хүннүд бууж өглөө, цянь нар хангийн алба татварт хэлмэгдэн туйлджээ. Гэтэл Чжанье, Цюцюань тойрог нь манай газар нутаг, энэхүү газар нутаг баялаг агаад үзэсгэлэнтэй, бид хамтдаа Ханг уулгалан довтолж, тэнд хамтдаа амьдарч болно” (Таскин 1968:163) хэмээн тэмдэглэгдсэн байна. Уг тойрог нь У-ди хааны үед хүннүгээс булаан авсан газарт байгуулагдсан тойрог бөгөөд Ганьсу мужийн баруун хойт этгээдэд оршдог ажээ.

Хүннүгийн умард хилийн тухайд, Маодун умард этгээдэд хуньюй, цюйшэ, динлин, тэгун болон синьлийн эзэмшил газрыг эрхэндээ оруулсан гэж дурдсан байх ба гэхдээ дээрх таван аймгаас зөвхөн динлин болон гэгун нарын тухай тодорхой зүйл ярих боломжтой. Судлаачид динлин нарыг МЭӨ III - МЭ V зууны үед Байгалаас Алтай хүртэлх өргөн уудам нутагт оршин сууж асан томоохон аймаг гэж үздэг бол гэгунь буюу цзяньгунь нэр нь орчин үеийн киргизүүдийн өвөг дээдэс гэдгийг судлаачид тогтоожээ.

Хүннүгийн умард хилийг Байгаль нуурын урдуур, дундуур, хойгуур байсан зэргээр янз бүрээр зурсаар иржээ. Хүннүгийн умард хилийн талаар сурвалжийн мэдээ хомс учир умард хилийг тодорхойлохдоо: 1) Хүннүгийн археологийн дурсгалын тархалт, 2) Сибирийн байгаль газар зүйн орчин, тэндхийн овог, аймгуудын нийгмийн хөгжлийн түвшин зэргийг харгалзан үзэх нь зүйтэй болов уу.

“... Сибирь нь монголчуудыг бодвол илүү сул дорой, илүү тархай бутархай овог аймгийн нутаг төдий л байсан” (Латимор 1994:18) бөгөөд судлаачдын хэлж байгаачлан Сибирийн ой тайгад тархай бутархай, цөөн хүн амтай, голчлон ан гөрөөгөөр амь зогоодог овгууд нь түүхийн бараг бүх үеийн турш Төв

Азид удаа дараа мандаж байсан улс гүрэнд дийлэнхдээ тайван замаар захирагдаж алба гувчуур төлснөөр хараат гэдгээ илэрхийлэн оршсоор иржээ.

Нөгөө талаар Хүннүгийн археологийн дурсгал Байгалийн дунд бие хүртэл нэлээд нягтралтай тархсаныг сүүлийн жилүүдэд эрчимтэй судалж байгаа бөгөөд судалгааны энэхүү үр дүнг үндэслэн Байгаль нуурын арыг хүртэлх нутгийг Хүннүчүүд хяналтандаа байлгаж байсан гэж үзэж болох байна.

Гэхдээ, Байгал далайгаас цааших газар нутаг нь эрт хүйтэрч их цас унадаг бэлчээрийн мал аж ахуй эрхлэхэд тохиромжгүй, гол төлөв хүчин мөхөс загасчин, анчин гөрөөчид оршин суудаг учир улс төр, эдийн засгийн талаас ач холбогдол өгдөггүй байсан бололтой бөгөөд хүннүгийн дараах төр улсуудын үед мөн л тийм болжээ. Иймээс нүүдэлчдийн хойт хил хязгаарыг түүхэнд болзолт байдлаар Байгал далайгаар заагладаг уламжлал тогтсон ажээ.

Нүүдэлчдийг нэг газарт тогтмол оршин суудаггүй мал маллан өвс, ус даган байнга нүүдэллэн аж төрдөг тухай нэг загвараар өмнө хөршийн бичгийн түшмэдүүд бичиж тодорхойлсоор ирсэн билээ. Гэтэл хэрэг дээрээ бүр хөгжингүй неолитийн үеэс гараагаа эхлэн мал аж ахуй нь хэдэн мянган жилийн хөгжлийн явцдаа Хүннүгийн үед асар өргөн уудам газар, бэлчээр нутгийг жилийн дөрвөн улиралд зохицуулан ашиглах тогтолцоог бий болгосон нь хоёр өөр ертөнц, нүүдлийн ба суурин иргэншил, хоёр өөр угсаатныг заагласан түүхэн хил хязгаар болон тогтсон ажээ. Хэрэв, хятадын Ян, Чжоу, Цинь улсууд умардын нүүдэлчдээс хамгаалан хэрэм далан босгоогүй бол, хэрэв, Цинь улсын Мэн Тянь жанжин хожим нь өөрийгөө зүй бусын үхэлд хүргэсэн Ордосын Бор тохойгоос Ляодун хүртэлх асар урт үргэлжилсэн бэхлэлт хэрмийг бариулаагүйсэн бол эдүгээ нүүдэлчид болон хятадын төр улсуудыг заагласан хил хязгаарын тухай асуудлыг бодит баримт дээр тулгуурлан хэлэлцэхэд тун түвэгтэй байх байсан болов уу. Энэхүү хил хязгаарыг МЭӨ 198 онд Хүннү, Хан хоёр

улсын хооронд байгуулсан албан ёсны иргэншлийн түүхэн дэх хилийн анхны гэрээ хэлэлцээгээр ёсчлон баталгаажуулсан нь мөн.

НОМ ЗҮЙ

- Батсүрэн Б.*, 2003. *Монголын эртний улсуудын нутаг дэвсгэр*. УБ.
- Бичурин Н.Я.*, 1950. *Собрание сведений о народах, обитавших в Средней Азии в древние времена*. Том I. М-Л.
- Гэрэлбадрах Ж.*, 2004. *Монголын нутаг дэвсгэр, хил хязгаарын түүх*. УБ.
- Ковалев А. А.*, 2002. Происхождение хунну согласно данным истории и археологии. В сб.: *Европа-Азия: Проблемы этнокультурных контактов*. СПб.
- Крюков М.В., Переломов Л.С., Софронов М.В., Чебоксаров Н.Н.*, 1983. *Древние Китайцы в эпоху централизованных империй*. Наука.
- Латтимор О.*, 1994. *Нүүдэлчид ба хувьсгалчид*. УБ.
- Малявкин А.Г.*, 1989. *Танские хроники о государствах Центральной Азии*. Новосибирск.
- Монгол улсын түүх.*, 2003. Тэргүүн боть.
- Сыма Цянь.*, 2002. *Исторические записки*. Том VIII. М.
- Таскин В.С.*, 1968. *Материалы по истории сюнну*. М.
- Таскин В.С.*, 1973. *Материалы по истории сюнну*. М.
- De Groot J. J. M.*, 1921. *Die Hunnen der vorchristlichen Zeit. Chinesische Urkunden zur Geschichte Asiens. Erster Teil*. Berlin; Leipzig, S. 48,
- Herrmann A.*, 1966. *An historical atlas of China*. (Based on Historical and Commercial Atlas of China by Albert Herrmann, published in 1935 by the Harvard-Yenching Institute Monograph Series, Volume I) Edinburgh, p. 10-11. Fig. The Hsiung-nu or Huns in Central Asia, I. 176 B.C, II. 128-36 B.C.
- Sima Qian*, 1993. *Records of the Grand Historian* (Translated by Burton Watson). Columbia University Press
- 司馬遷。史記。全六冊，樂天出書局。初版中華民國六十三年。

ХУРААНГУЙ

P.DELGERJARGAL, Z.BATSAIKHAN

THE TERRITORY AND BORDERS OF XIONGNU (IN THE PERIOD 176-128 BC)

In this paper authors present the map of Xiongnu in the period of its most expansion and results of the researches conducted for the construction of the map.

ХҮННҮ (ХҮН) ГҮРЭН МЭӨ 209-МЭ 93(156) ОН



Зураг 1. Хүннүгийн хил хязгаар, нутаг дэвсгэр